

ХЯТАДЫН ӨМНӨД СҮН УЛСЫГ МӨХӨӨХӨД БАЯН ЖАНЖИНЫ ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

Н.ТӨМӨР*

Юан гүрний үед нэр цууд гарсан төр улс, бичиг ссёлын болон цэргийн өдий төдий зүтгэлтэн монгол хүн байжээ. Юан гүрний үед мөн хэд хэдэн Баян нэртэй төр, цэрэг бичгийн түшмэл байсан. Энэхүү өгүүлэлд өгүүлж буй Баян жанжин бол Хубилай хаан хятадын Өмнөд Сүн улсыг мөхөөж, бүх хятадыг эзлэн авахад нэлээд их үүрэг гүйцэтгэж, монголын цэргийг тэргүүлэн Өмнөд Сүн улсыг эзлэн авах тулалдаан байлдаанд биеэр оролцож байсан Монголын Баарин аймгийн хүн. Сурвалж бичгийн мэдээнээс үзвэл, Баян жанжины өвөг дээдсээс эхлэн Чингисийн удмынхантай дотно харилцаж байсан бөгөөд түүний элэнц эцэг Ширээт нь Чингисийн захиргаан дор алба хааж Баарин аймгийн зүүн мянгатын захирагч байлаа. Баян жанжины өвөг эцэг Алаг, эцэг Ширээтийнхээ мянгатын захирагчийн албан тушаалыг үе залгамжлан авч шүүхийн заргачийн албыг хавсран гүйцэтгэж байв.¹ Баян жанжин багадаа өөрийн эцэг Кокиутай хамт Мөнх хааны дүү Хүлэгүтийн баруун зүгт хийсэн аян дайнд цуг явж байсан тухай түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг.²

Хубилай хаан, Баяныг чухалчлан үзэх болсон нь чухамдаа дээр дурдсан түүний гарал үүсэлтэй холбоотой байж болох юм. Хубилай хааны эхэн үед буюу 1264 оны үед Баян Хүлэгүтийн илгээсэн элч төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж, Ильханы улсаас Юан улсад ирж Хубилай хаанд бараалахад тэрээр хаанд ихэд таашаагдсан учир түүнийг нутагт нь буцаалгүй, өөрийн шадар сайд болгон үлдээжээ.³

Мөнх хааны дараа Чингисийн “Алтан ургийнханы” дунд хаан ширээний төлөө тэмцэл дахин гарчээ. Үүнээс өмнө Өгэдэй, Тулуйн угсааны ноёдын хооронд тэмцэл гардаг байсан бол энэ удаа Тулуйн хоёр хүү Хубилай, Аригбөх нар хаан ширээний төлөө тэмцэх болжээ.

Мөнх хааны дараа Аригбөх улс нутаг, нийслэл хотоо сахиж үлдсэн аятай байдлыг ашиглан их гүрний хаан ширээнд суужээ. Гэтэл Хубилай, Аригбөхийн хаан ширээнд суух болсныг мэдмэгц Долоон нуур дахь Кайпин хотод 1260 онд биеэ мөн их хаан гэж өргөмжилжээ. Ийнхүү 1260 оны үед Монголын их гүрэнд хоёр хаан гарч, Хубилай, Аригбөх хоёр хаан ширээний төлөө тэмцэж, эцэст нь Хубилай Аригбөхийг ялж, Монгол гүрний хаан болжээ.

* Н.Төмөр - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Хубилай Аригбөхийг ялсны дараа Өмнөд Сүн улсыг эзэлж, Хөх мөрний өмнө талын хятадын газар нутгийг нэгтгэн авч, ноёрхлоо тогтохыг зорьж байв. Тэр үед умард хятадын бүх газар нутаг монголчуудын эрх мэдэлд орж, Өмнөд Сүн улс нь хятадын зөвхөн урьд хэсгийг эзэлж байснаас гадна, дотоодын зөрчил тэмцэл хурцдаж, эрх танхил, баялаг тансагт умбасан Өмнөд Сүн улсын хаан, феодал ноёд нь харийн түрэмгийлэлийн эсрэг ард түмний хүчийг нэгтгэн зохион байгуулж чадахгүй байлаа.

Хубилай хаан дээр дурдсан байдлыг ашиглаж өмнөд Сүн улсыг байлдан эзэлхээр шийдэж, монголын цэргийг Баян жанжнаар захируулан мөрдүүлжээ.

Өгэдэй хаан Алтан улсыг мөхөөснөөс хойш монголын цэрэг өмнөд Сүн улсыг удаа дараалан дайран довтолж байсан боловч Хубилайг хаан болох хүртэл түүнийг эзлэн авч чадаагүй байсан хэвээрээ учраас Өмнөд Сүн улсыг мөхөөж, Хөх мөрний өмнө талын хятадын газар нутгийг эзэлж авах нь монголын феодал ноёдын стратегийн зорилтын нэг болсоор байлаа. Хубилай хаан, хятад түшмэл Яо Шугийн саналыг хүлээн авч, өмнөд Сүн улстай хил залгаа орчим газар нутагт цэрэг байрлуулан, цэргийн сургууль хийхийн зэрэгцээ атарыг эзэмшүүлж байлаа. Энэ нь хожим хойно өмнөд Сүн улсыг дайрч довтлоход түшиц газар болж байлаа.

1261 оны зун өмнөд Сүн улсын нөлөө бүхий жанжин Лю Чжэн 30 түмэн өрхийн ард иргэдийг дагуулан монголын талд орж иржээ.⁴ Лю Чжэн өөрийн улсын цэргийн хамаг нууцыг задалж газарчлан байлдах болсон явдал өмнөд Сүн улсад бүр ч их аюул учруулжээ. 1267 онд Лю Чжэн, Хубилай хаанд зөвлөж хэлэхдээ, Өмнөд Сүн улсыг мөхөөхөд юуны өмнө Сяньян хэмээх хотыг /одоогийн БНХАУ-ын Хубэй мужийн Сяньфань хот/ эзэлж авах хэрэгтэй ажээ.⁵

Сяньян хотыг байлдан эзлэхэд их хэмжээний усан цэргийн хүч хэрэгтэй байсан учир Хубилай хаан Лю Чжэн тэргүүтэй ноёдыг ашиглан 1270 онд таван мянган байлдааны усан онгоц, долоон түмэн хүнтэй усан цэргийн хүчийг байгуулжээ.⁶

1268 оны намар өрлөг жанжин Ачжу олон газрын цэргийг тэргүүлэн Сяньян хотыг бүслэн дайрч, мөн онд монголчууд Сяньян руу хоол хүнс залгуулахыг саатуулах зорилгоор Ханьшуй мөрөн дээр болон Сяньян хотын хавь газар хэд хэдэн бэхлэлт байгуулжээ.⁷ 1268 оны 9-р сард Ачжу жанжины цэрэг Сяньяны эсрэг талд, Ханьшуй мөрний зүүн эрэг дээр орших Фанчэнь хэмээх хотыг бүслэв.⁸ 11-р сард Өмнөд Сүн улсын цэрэг монголчуудын барьсан бэхлэлтийг Сяньянаас гарч дайрчээ. Ингэхэд Ачжу цэргийн хүчээ зөв хувиарлан хувааж, зохион байгуулж чадснаар дайран довтолсон өмнөд Сүн улсын цэргийг хиар

цохив. Энэ удаагийн тулалдаанд монголын цэрэг жанжин нараас 1304 хүн байлдааны гавъяа байгуулсан гэж “юан улсын судар”-т тэмдэглэжээ.⁹ 1269 оны 1-р сард Ачжугийн цэрэг байлдааны цар хүрээг өргөжүүлж Фучжоу, Дэ-ань фу, Цзиньшань зэрэг хот сууринд цөмрөн орж Өмнөд Сүн улсын 10 мянга гаруй цэргийг олзолжээ.¹⁰ 1269 оны 7-р сард удтал орсон борооны улмаас Ханшуй мөрний усны түвшин ихэссэнийг далимдуулан Өмнөд Сүн улсын цэргийн жанжин Ся Гуй, фань Вэньху нар цэргээ дагуулан Сяньянд туслахаар ирэхэд монголын цэрэг угтан байлдаж, Өмнөд Сүн улсын 100 гаруй байлдааны усан онгоцыг олзолж авснаас гадна, таван мянга гаруй цэргийн заримыг нь алж, заримыг нь олзлон авчээ.¹¹ Мөн оны 9-р сард Өмнөд Сүн улсын жанжин Чжан Шунь, Чжан Гуй нар цэргээ дагуулан Сяньянд туслахаар ирсэн боловч бас л амжилтгүй болж, монголын цэрэгтэй байлдах үед алуулжээ.¹²

Фанчэнь хотыг эзэлж авахын тулд Ачжу тэргүүтэй монголын цэрэг фанчэнь хотыг гаднын ямар нэг тусламж авахгүй байлгах шаардлагатай байсан учир Сяньян хоттой Ханшуй мөрнийг дайруулан холбосон гүүрийг эвдэн шатаажээ.¹³ Үүнээс болж фанчэнь нь Сяньянаас ямар ч тусламж тусалцаа авах боломжгүй болсон учир 1272 оны 12-р сард монголын цэрэгт эзлэгджээ.¹⁴

Фанчэнь хот монголын цэрэгт эзлэгдснээр Сяньян хотын хувь заяа бас шийдэгдэж, Сяньян хотыг хамгаалж байсан Люй Вэньхуань Фанчэнь хот эзлэгдсэн тухай мэдээ сонсоод их айн эмээж, цаашид эсэргүүцэн тэмцэх явдлыг ултагүй болсон хэмээн үзээд удалгүй монголын цэрэгт бууж өгчээ.⁵⁵

Сяньян, Фанчэнь хоёр хот автсан явдал Өмнөд Сүн улсад асар том цохилт болжээ. Энэ хоёр хотыг эзэлснээр Хубилай хааны Өмнөд хятадыг эзлэх ерөнхий төлөвлөгөөний эхний хэсэг биелэгдлээ.

Тэр үед Өмнөд Сүн улсын дотоодын зөрчил хурцдаж, эрх танхил, баялаг тансагт умбасан Өмнөд Сүн улсын хаан, феодал ноёд үхлийн аюулд орсноо ч ойлгоогүй, тийм учраас Сяньян, Фанчэнь хоёр хотыг аварч туслах талаар Өмнөд Сүн улсын хааны ордноос ямар ч арга хэмжээ авсангүй. Монголчууд ч зохион байгуулттай эсэргүүцэл Өмнөд Сүн улсаас үзүүлж чадахгүй гэдгээ мэдэж байжээ. Тэдний замд учрах саад болох эх орноо аврах үзэлтэй хүн ард, цэргийн хэд хэдэн жанжин л байж болох ажээ.

1274 оны хаврын тэргүүн сард Ачжу, Арикай жанжин нар Өмнөд Сүн улсыг бүрмөсөн эзлэн авах цаг мөч хүрч ирлээ гэж Хубилай хаанд итгүүлж чадлаа.¹⁶ Мөн онд тэргүүн сайд Ши Тяньцзэгийн зөвлөснөөр байлдан дагууллыг удирдах ерөнхий жанжнаар Баянг томилохын хамт түүнийг бас засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яамны зүүн тэргүүн сайдаар давхар томилон цэрэг хөдөлгөхөөр зарлиг

буулгажээ.¹⁷

Монголын цэрэг 1274 оны 9-р сард Сяньянд хуран цугларч, Өмнөд Сүн улсыг дайран довтолхоор цэргээ хоёр чиглэлээр хөдөлгөхөөр Баян жанжин шийдэж тушаал буулгажээ.¹⁸ Нэг замын цэргийг Баян жанжин, Ачжутаг хамт удирдан Сяньянаас гараад Ханьшуй мөрний дагуу Хөх мөрөн рүү гарч, Өмнөд Сүн улсын нийслэл /Линьань хотыг /одоогийн БНХАУ-ын Чжэцзян мужийн Ханьчжоу хот/ эзэлхээр, нөгөө замын цэргийг Хэда, Дун Вэньбинь нараар удирдуулан зүүн чиглэлээр Яньчжоу хотыг /одоогийн мөн Яньчжоу хот/ эзэлж авахаар тус тус морджээ.¹⁹

1274 оны 9-р сард монголын цэрэг Эчжоу /одоогийн БНХАУ-ын Хубэй мужийн Учан хот, /Ханьян/ одоогийн БНХАУ-ын Хубэй мужийн Ханькоу хот/ зэрэг хотуудыг эзэлж авсаны дараа Баян, Арикай жанжиныг Эчжоугийн хамгаалах захирагчаар томилон, дөрвөн түмэн цэргийг түүгээр удирдуулан Хубэй, Хунань зэрэг мужуудын эзлэгдээгүй хот суурин газруудыг эзэлж авахыг тушаал буулган, Баян жанжин өөрөө Ачжу зэрэг цэргийн жанжин нарын хамт их цэргийг дагуулан Хөх мөрний дагуу зүүн тийш Өмнөд Сүн улсын нийслэл /Линьань хот/ одоогийн БНХАУ-ын Чжэцзян мужийн Ханьчжоу хот/ баримжаалан цаашид давшилт хийв.²⁰

1275 оны хаврын тэргүүн сард Хуанчжоу /одоогийн БНХАУ-ын Хубэй мужийн Хуанган сяний нутаг дэвсгэрт оршиж байсан/ хэмээх газрыг Баян жанжин, Арикай нар эзэлж авсны дараа Чичжоу /одоогийн БНХАУ-ын Хубэй мужийн Чичунь сянь/, Цзянчжоу /одоогийн БНХАУ-ын Цзяньс мужийн Цзюйцзян хотын орчим газар нутагт оршиж байсан/, Аньшин /одоогийн БНХАУ-ын Аньхой мужийн Аньшин хотын орчим газар нутагт оршиж байсан / зэрэг хот цайзын цэргийн жанжин, захирагчид монголын цэрэгт ямар ч эсэргүүцэл үзүүлэлгүйгээр шууд бууж өгөв. 1275 оны эхний гурван сар бол Баян жанжины цэрэг Хөх мөрний дагуу Хубэй, Аньхой, Цзянси мужуудаар давшиж Өмнөд Сүн улсын цэргийн жанжинууд, хот цайзын захирагчид газар сайгүй урван бууж өгч байсан үе байлаа.²¹

Сүн улсын тэргүүн сайд Цзя Сыдао алдсан газруудаа Баян жанжинтай найрамдал байгуулж, жил бүр алба гувчуур төлж байхаар эргүүлж авах тухай захидлыг элчээ Сун Цзинээр хүргүүлсэн боловч Баян жанжин түүнд тагталзсан хариу өгөв.²² Цзя Сыдао үүний хариуд арван гурван түмэн цэрэг, хоёр мянган таван зуун байлдааны усан онгоцыг дайчлан Баян жанжинтай байлдахаар шийджээ. Гэвч хятадын цэрэг бут ниргүүлж, Цзя Сыдао өөрөө Яньчжоу хэмээх газар руу зугтжээ.²³ Сүн улсын зугтаасан цэргүүдийг Баян жанжины цэргүүд араас нь 50 гаруй ли /ли –уртын нэгж бөгөөд 0,5 км-тэй тэнцэнэ/ газар элдэн

хөөсөөр их олз булаан авсны дотор зэр зэвсэг, газрын зураг, түшмэдийн тамга, хоёр мянга гаруй байлдааны усан онгоц байжээ.²⁴

1275 оны 3-р сард Баян жанжины удирдлагын дор монголын цэрэг Цзянькан /одоогийн Нанжин хот/-г эзлэн авчээ.²⁵ Үүний дараа монголын цэрэг Хөх мөрнөөр үргэлжлэн явсаар 1275 оны намраас бүх дорнод хятадаар өргөн давшилт хийж билээ. Сүн улсын цэргийн жанжнууд дараа дараагаар урвах буюу зугтаан зайлснаас хэд хэдэн том хот бууж өглөө.²⁶ 1275 оны 11-р сард Өмнөд Сүн улсын нийслэл Линьанийг дайран довтолхоор цэргээ гурван чиглэлээр хөдөлхөөр Баян жанжин шийдэж тушаал буулгасан²⁷ ба 1296 оны 3-р сард монголын цэрэгт Линьянь хот эзлэгдснээр Өмнөд Сүн улс мөхжээ.²⁸ Харин хятадын зүүн-өмнө зүгийн муждалд монголын цэрэг гурван жил /1276-1279/ орчим хугацааг зарцуулж байж сая эсэргүүцлийн сүүлчийн голомтыг устгаж чадсан билээ.²⁹

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. "Монголын нууц товчоо", УБ., 1957, 107 дахь тал: "Юан улсын судар" /"Юанши"/, Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3099 дэх тал.
2. "БНМАУ-ын түүх", УБ., 1966, 1 –р боть, 340-345 дахь тал; Рашид-ад-Дин. "Сборник летописей" т.1, кн.1, 1888 дахь тал, "Юан улсын судар" /"Юанши"/ , Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3099 дэх тал
3. "Юан улсын судар" /"Юанши"/ , Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3099 дэх тал
4. "Юан улсын судар" /"Юанши"/ , Бээжин, 1976, 12-р дэвтэр, 3786 дахь тал.
5. Мөн тэнд.
6. "Юан улсын судар" /"Юанши"/ , Бээжин, 1976, 12-р дэвтэр, 3787 дахь тал.
7. "Юан улсын судар" /"Юанши"/ , Бээжин, 1976, 1-р дэвтэр, 119 дэхь тал. 10-р дэвтэр, 3120 дахь тал, 12-р дэвтэр, 3786-3787 дахь тал.
8. "Юан улсын судар" /"Юанши"/ , Бээжин, 1976, 1-р дэвтэр, 119 дахь тал.
9. "Юан улсын судар" /"Юанши"/ , Бээжин, 1976, 1-р дэвтэр, 120 дахь тал.
10. "Юан улсын судар" /"Юанши"/ , Бээжин, 1976, 1-р дэвтэр, 121 дэхь тал.
11. "Юан улсын судар" /"Юанши"/ , Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3120 дахь тал.
12. Мөн тэнд.
13. Мөн тэнд.

14. "Юан улсын судар" /"Юанши"/ , Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3120 дахь тал.

12-р дэвтэр, 3788 дахь тал; Цюй Шусэнь: "Юан улсын түүхэн яриа" /"Юанчао шихуа"/, Бээжин, 1980., 75-76 дахь тал.

15. Мөн тэнд.

16. "Юан улсын судар" /"Юанши"/, Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3120-3121, 3125 дахь тал.

17. "Юан улсын судар" /"Юанши"/, Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3125 дахь тал:

Су Тяньцзюе: "Юан төрийн нэрт түшмэдийн хэргийн товч" /"Юанчао минчэн шилюэ" /, Шанхай, 1936, 1-р дэвтэр, 13 дахь тал.

18. "Юан улсын судар" /"Юанши"/, Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3100 дахь тал.

Цюй Шусэнь: "юан улсын түүхэн яриа" /юанчао шихуа"/, Бээжин, 1980, 76 дахь тал.

19. Мөн тэнд.

20. "Юан улсын судар" /"Юанши"/, Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3103 дахь тал.

Су Тяньцзюе: "Юан төрийн нэрт түшмэдийн хэргийн товч" /"Юанчао минчэн шилюэ"/, Шанхай, 1936., 1-р дэвтэр, 14 дэх тал.

21. "Юан улсын судар" /"Юанши"/, Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3104 дэхь тал.

22. "Юан улсын судар" /"Юанши"/, Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3104 дэхь тал. Цюй Шусэнь: "Юан улсын түүхэн яриа" /"Юанчао шихуа"/ , Бээжин, 1980, 76 дахь тал

23. "Юан улсын судар" /"Юанши"/, Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3104-3105 дахь

тал. Су Тяньцзюе: "юан төрийн нэрт түшмэлийн хэргийн товч" /"Юанчао минчэн шилюэ"/, Шанхай, 1936, 1-р дэвтэр, 14 дэх тал.

24. Мөн тэнд.

25. Мөн тэнд.

26. "Юан улсын судар" /"Юанши"/, Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3106-3107 дахь тал.

27. "Юан улсын судар" /"Юанши"/, Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3107 дахь тал. Су

Тяньцзюе: "Юан төрийн нэрт түшмэдийн хэргийн товч" /"Юан чао минчэн шилюэ"/, Шанхай, 1963, 1-р дэвтэр, 15 дахь тал.

28. "Юан улсын судар" /"Юанши"/, Бээжин, 1976, 10-р дэвтэр, 3112 дахь тал. Су Тяньцзюе: " Юан төрийн нэрт түшмэдийн хэргийн товч" /"Юанчао минчэн шилюэ"/, Шанхай, 1936, 1-р дэвтэр, 15 дахь тал.

29. "БНМАУ-ын түүх", УБ., 1966, 1 боть, 292 дахь тал: Чжан Чуаньси: "Хятадын эртний түүхийн найруулал" /"Чжунго гудай шиган"/, Бээжин, 1989, дэд дэвтэр, 292 дахь тал